Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Ж.Өсөхбаяр, Б.Нарангэрэл нар гүйцэтгэв.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 19/237 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Засаг дарга нь “Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, хүний болон эдийн засгийн хөгжлөөрөө Монгол Улсын тэргүүлэх аймгуудын нэг болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- “Баянхонгорын иргэд - Баянхонгорын баялаг” зарчмыг удирдлага болгож, иргэдээ бүх талаар системтэй хөгжүүлнэ.
- Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг тэргүүлэх аймгуудын хэмжээнд хүргэх.
- Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийг багасгаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэхийг зорьж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх.
- Соёл, урлаг, биеийн тамир спорт нь хүний хөгжлийн чухал хүчин зүйл хэмээн үзэж бүх талаар дэмжиж хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх.
- Хүний хөгжлийг дээдэлсэн иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн халамжийн оновчтой бодлогыг тууштай хэрэгжүүлэх.
- Бүс нутгийн хэрэглээг хангахад чиглэгдсэн томоохон үйлдвэрүүдийг байгуулах, импортыг орлосон, гадаад зах зээлд чиглэгдсэн, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэн үйлдвэржилтийн хувьсгал хийж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр дахин өсгөж, 2000-аас доошгүй иргэнийг тогтвортой байнгын шинэ ажлын байраар хангаж, ядуурлыг хоёр дахин бууруулах.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг тогтвортой нэмэгдүүлэх зарчим баримталж, таваарлаг мал сүрэгтэй, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлж иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх.
- Үйлдвэрлэл, үйлчилгээг тэтгэсэн, иргэдийнхээ эрэлтэд нийцсэн дэд бүтцийг бий болгоно.
- Авлигаас ангид, нээлттэй, ил тод, улс төрөөс ангид, шударга ёс, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёсыг эрхэмлэж ард түмнээ дээдэлсэн, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангасан, мэргэшсэн хариуцлагатай, ардчилсан төрт ёсыг бэхжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2019.03.22-ы өдөр “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн шинэчлэн найруулан баталж 2020.01.01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн.
- УИХ-аас 2020.04.29-ны өдөр “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталж мөрдүүлсэн.
- Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхэд, дотуур байрны хүүхдийн нэг хоногийн хоолны зардал, үдийн цайны нэг өдрийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс 2020.01.01-ний өдрөөс эхлэн аймагт үйл ажиллагаа явуулж буй дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн 1м³ халаалтын талбайн хөлсийг өмнөх оноос 8 хувиар нэмэгдүүлж тогтоосон байна.
- БСШУС-ын сайдын 2020.04.13-ны өдрийн 1а/2235 тоот албан бичгээр Ковид-19 вируст халдвараас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020.01.27-ны өдрөөс, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн тогтоолоор тус тус бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоох чиглэл ирүүлсэн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар 13 байгууллага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй ба төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь байгууллагын онцлог үйл ажиллагаатай уялдаагүйгээс санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахгүй дахин шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Иймд төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны онцлогтой уялдуулж, хууль, журамтай нийцүүлэн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороо 2020 онд 2 удаагийн хуралдаанаар 5 асуудлыг хэлэлцэж, 2 тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт 87, төлөвлөгөөт бус 4, нийт 91 хяналт шалгалт хийж, аудитаар нийт 600.7 сая төгрөгийн зөрчилд 132 төлбөрийн акт тогтоож, 63.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 537.0 сая төгрөгийг тухайн шалгагдагч байгууллагын дансанд оруулахаар шийдвэрлэсэн бөгөөд актын биелэлт 68.0 хувьтай байна.

Мөн Санхүүгийн хяналт аудитын алба нь аймгийн Прокурорын газартай хамтран Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т заасны дагуу 2.4 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулж холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 148813.6 сая төгрөгийн 0.5 хувь буюу 744.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Төлөвлөлтийн шатанд аудитын үр өгөөжийг 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт төсөвт зардлын 0.2 хувиар тооцож 159.7 сая төгрөгөөр тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 246927.2 сая төгрөг болж өмнөх оноос 12.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр/өмч сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Дүнд эзлэх хувь	
				Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	26,068.9	31,030.5	4,961.6	11.9	12.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	193,296.6	215,896.8	22,600.2	88.1	87.4
Нийт хөрөнгийн дүн	219,365.4	246,927.2	27,561.8	100.0	100.0
Нийт өр төлбөр	9,827.1	11,293.3	1,466.3	4.5	4.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	209,538.4	235,633.9	26,095.5	95.5	95.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	219,365.4	246,927.2	27,561.8	100.0	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7843.8 сая, эцсийн үлдэгдэл 9519.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1675.4 сая төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 8744.2 сая буюу 91.9 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 775.0 сая буюу 8.1 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+), Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
Кассад байгаа бэлэн мөнгө	3.9	1.1	1.1	-	-	(2.7)
Төгрөг/ ЖМС	3.9	1.1	1.1			(2.7)
Нэмэлт санхүүжилтийн Касс	-	-				-
Банканд байгаа бэлэн мөнгө	7,840.0	9,518.1	-	775.0	8,743.1	1,678.1
Төгрөг	7,840.0	9,518.1		775.0	8,743.1	1,678.1
Гадаад валют	-	-				-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-				-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	7,843.9	9,519.2	1.1	775.0	8,743.1	1,675.3
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>						
Төрийн сан	2,400.5	3,610.6			3,610.6	1,210.1
Төсөвт байгууллагууд /ОНХС, СХС, Замын сан/	1,977.1	2,157.5		26.0	2,131.4	180.4
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	1,037.6	749.3	1.1	748.2		(288.3)
Төсөл, сангууд	2,428.7	3,001.8		0.7	3,001.1	573.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1. Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө оны эхэнд 2400.4 сая төгрөг байснаас оны эцэст 3610.6 сая төгрөг болж өмнөх оноос 1210.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь орон нутгийн давсан орлогын зарцуулагдаагүй 2554.4 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн 940.0 сая, урьд оны харилцах дансны 116.3 сая төгрөгийг зарцуулаагүйгээс нийт 3610,6 сая төгрөг байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Орон нутгийн давсан орлого	Буцаан төвлөрүүлэлт	Үүнээс		Өсөлт (+), Бууралт (-)
					Урьд оны зарцуулаагүй үлдэгдэл		
Баянхонгор аймаг	1302.4	1,848.5	1,446.5	402.0			546.1
Галуут	44.4	61.8	45.4	16.4			17.4
Баян-овоо	36.6	47.9	38.1	9.8			11.3
Эрдэнэцогт	17.3	83.1	59.7	23.4			65.8
Бууцагаан	23	114.8	59.3	32.5	23.0		91.8
Жинст	43.8	40.3	20.0	6.2	14.1		(3.5)
Богд	22.1	55.0	21.1	30.0	3.9		32.9
Баянлиг	27.7	61.1	35.7	25.4			33.4
Баянговь	51.9	53.3	43.7	9.6			1.4
Гурванбулаг	54.6	105.2	93.1	12.1	0.0		50.6
Жаргалант	32.8	47.8	42.9	5.0	-		15.0
Заг	39.9	59.5	12.6	25.6	21.3		19.6
Баацагаан	26.8	28.9	21.6	7.4	0.0		2.1
Бөмбөгөр	24.1	169.9	163.0	6.9			145.8
Өлзийт	56.4	62.7	30.3	32.4			6.3
Хүрээмарал	82.4	60.8	32.8	16.3	11.7		(21.6)
Баянбулаг	27.5	90.9	27.3	61.4	2.1		63.4
Шинэжинст	78.5	81.7	54.3	27.4			3.2
Баянцагаан	68.4	53.1	26.2	26.9			(15.3)
Баян-өндөр	104.3	125.2	59.1	25.9	40.2		20.9
Баянхонгор	235.6	359.4	221.8	137.5	0.0		123.8
Нийт дүн	2,400.4	3,610.6	2,554.4	940.0	116.3		1,210.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 1460.2 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн орлого 14243.4 сая төгрөг бүрдүүлж, 11573.0 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд зарцуулжээ.

Тайлант оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 3610.7 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 1762.2 сая төгрөг нь 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бөгөөд оны эцэст аймгийн төвийн төсөвт байгууллагууд зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс 402.0 сая, төлөвлөгөөнөөс давсан орлогын 1446.4 сая, нийт 1848.5 сая төгрөг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр байна.

2. Төсөвт байгууллага, сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1977.1 сая, эцсийн үлдэгдэл 2157.5 сая төгрөг болж, өмнөх оноос 180.4 сая төгрөгөөр өссөн ба сум хөгжүүлэх сангийн 1477.8 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 641.5 сая, замын сангийн 12.1 сая, өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл 26.0 сая төгрөг байна.

Хүснэгт 4. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	СХСан	ОНХСан		СХСан	ОНХСан	Замын сан	Өрхийн эмнэлгүүд
Галуут	53.9	106.3	Баацагаан	20.2	18.0	-	-
Баян-Овоо	15.1	10.8	Бөмбөгөр	24.3	66.8	-	-
Эрдэнэцогт	56.3	10.8	Өлзийт	122.8	15.5	-	-
Бууцагаан	18.9	10.6	Хүрээмарал	11.6	14.2	-	-
Жинст	61.1	15.1	Баянбулаг	12.9	27.8	-	-
Богд	68.9	1.4	Шинэжинст	23.8	58.5	-	-
Баянлиг	119.8	78.1	Баянцагаан	55.4	55.7	-	-
Баянговь	135.8	0.2	Баян-Өндөр	41.5	81.1	-	-
Гурванбулаг	37.5	3.1	Баянхонгор сум	471.8	6.9	-	-
Жаргалант	61.8	26.4	Аймгийн ОНХС	-	4.8	-	-
Заг	64.6	29.3	Аймаг	-	-	12.1	26.0
Нийт дүн				1,477.8	641.5	12.1	26.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3. Төсөл сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 573.1 сая төгрөгөөр өсөж, 3001.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 2076.4 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, 428.5 сая төгрөг нь ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны барьцаа, орон нутгийн нөөц сангийн дансны үлдэгдэлд байгаа 496.2 сая төгрөг нь төсвийн байгууллагуудын нэмэлт дансны буцаан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 5. Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн нөөц сан	243.2	496.2	253.0	16.5
Техник хяналт данс	1,601.8	2,504.9	903.1	83.5
Барьцаа хөрөнгийн данс	503.4	-	(503.4)	-
Хөрөнгө оруулалтын барьцаа данс /Хас банканд байршуулсан-ЖДҮ/	75.0	-	(75.0)	-
Байгаль хамгаалах зардал	5.3	-	(5.3)	-
Нийт дүн	2,428.7	3,001.1	572.4	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7¹-т заасны дагуу ТШЗ-ийн 58 байгууллага нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 496.2 сая төгрөгийг оны эцэст орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Дээрх хөрөнгийг Сангийн яам төв Төрийн сантай тооцоо нийлж авлага, өглөгийг ТШЗ-ийн санхүүгийн тайланд тусгаагүй үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4², 14 дүгээр зүйлийн 14.4.2³-т заасантай нийцэхгүй байгаа тул цаашид оны эцэст төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн үлдэгдлийг зарцуулах тухай шийдвэрийг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор гаргуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж авлага, өглөгийг тухай бүр санхүүгийн тайланд тусгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

¹ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

² "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна"

³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

4. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө:

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1110.1 сая, эцсийн үлдэгдэл 775.0 сая төгрөг болж, 335.1 сая төгрөгөөр өссөн бөгөөд үлдэгдлийн 96.5 хувийг ТӨҮГ болон ОНӨААН-ийн үлдэгдэл, 0.1 хувийг төсөл сангийн үлдэгдэл, 3.4 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Хүснэгт 6. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	0.2	26.0	25.8	3.4
Төсөл/ сан	75	0.7	(74.3)	0.1
Төрийн сан	0.03	-	(0.0)	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1034.9	748.2	(286.7)	96.5
Дүн	1110.1	775.0	(335.1)	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 748.2 сая төгрөг байгаагаас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 616.0 сая, “Чандмань Баянхонгор” ХК-ийн үлдэгдэл 11.3 сая, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн үлдэгдэл 120.8 сая төгрөг байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсөв байгууллагын арилжааны банкны үлдэгдэл 26.0 сая төгрөг байгаа нь аймгийн төвийн 4 өрхийн эмнэлгийн харилцах дансны үлдэгдэл байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Хас банканд хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршиж байсан 75.0 сая төгрөгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д шилжүүлж дансыг хаасан ба тайлант онд татан буугдсан “Баянхонгор хайрхан фарм” ОНӨАТҮГ-ын арилжааны банкин данс харилцах дансны үлдэгдэл 0.7 сая төгрөгийг төрийн сангийн үлдэгдлээр тайлагнасан ба харилцах дансны үлдэгдэл 2021 онд хаасан байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7497.4 сая, эцсийн үлдэгдэл 7902.6 сая төгрөг болж, 405.2 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 72.6 хувийг сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, болон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр олгосон зээлүүд эзэлж байна.

Хүснэгт 7. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Ажилчидтай холбогдсон авлага	21.4	35.9	14.5	0.5
Төлбөрт үйлчилгээний авлага	110.4	45.7	(64.7)	0.6
Татаас, санхүүжилтийн авлага			-	-
Зээлийн хүүгийн авлага		2.4	2.4	0.0
Дансны авлага /ТӨҮГ/	0.6	0.1	(0.6)	0.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.9		(0.9)	-
Бусад авлага	1,903.3	2,083.5	180.2	26.4
Зээлийн авлага	5,460.7	5,735.1	274.4	72.6
Дүн	7,497.4	7,902.6	405.3	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр:			-	-
Төсөвт байгууллага	5,491.7	5,408.1	(83.6)	68.4
Төсөл/сан	714.5		(714.5)	
Төрийн сан			-	
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,291.2	2,494.5	1,203.3	31.6
Нийт дүн	7,497.4	7,902.6	405.2	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жил болсон насжилт өндөртэй 666.6 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-аар дамжуулан олгосон 4-өөс дээш жилийн насжилттай хугацаа хэтэрсэн 38 зээлдэгчийн 615.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл;
- Гурванбулаг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын хувь хүнээс авах 3.0 сая төгрөгийн авлага;
- Аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2005 онд үүссэн аймгийн “Цахилгаан холбоо” ХК-аас авах 1.8 сая төгрөгийн авлага;
- “Чандмань Баянхонгор” ХК-ийн санхүүгийн тайланд 2010 оноос хойш шийдвэрлэгдээгүй Хот тохижилттой холбоотой 22.4 сая, аймгийн ЗДТГ-ын бор балгасын усжуулалтын системтэй холбоотой 11.4 сая төгрөгийн авлага;
- Эрдэнэмандал ахлах сургуулийн өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнтэй холбоотой 2019 онд үүссэн 6.3 сая төгрөгийн авлага;
- Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн нярваар ажиллаж байсан иргэнтэй холбоотой 0.6 сая төгрөгийн авлага;
- Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2011 онд үүссэн дизель мотор түрээслүүлсний 3.0 сая төгрөгийн авлага;
- Шинэжинст сумын хүүхдийн Цэцэрлэгийн 2012 онд үүссэн “Ган мөнхжин” ХХК-аас авах зураг төсвийн 2.7 сая төгрөгийн авлага барагдаагүй үлдэгдлээр байна.

Олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн дээрх авлагууд нь тооцоо нийлсэн актгүй, олон жил болсноос эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон, аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах болон хөнгөлөлттэй зээлийг үр ашиггүй зүйлд зарцуулж, төсвийн хөрөнгийн үргүйдэх, найдваргүй авлага үүсэх сөрөг үр дагавартай тул ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар оны эцэст хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэлгүй бэлтгэн нийлүүлэгч байгууллагад шилжүүлж авлагаар бүртгэдэг, цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлдэггүй, даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс авлага, өглөг үүссэн байхад залруулга хийдэггүй, мөн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

Тухайлбал

- Аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/770 дугаар захирамжаар аймгийн ЕБС тус бүрд “хичээл практик”-ийн зардлыг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүний дагуу ухаалаг самбар худалдан авахаар 9.9 сая төгрөгийг холбогдох компаниуд руу шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг 2020 онд багтаан хүлээж аваагүй авлагаар тусгасан.
- Цалингийн зардлын тооцооллыг 66.7 сая төгрөгийн авлагыг нийт 19 байгууллага зөрүүтэй тайлагнасан.
- Бэлтгэн нийлүүлэгчтэй хийх тооцооллыг 12 байгууллага 31.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- ТШЗ-ийн болон ОНӨААН-ийн нийт 8 байгууллага 666.6 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй.
- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд санхүүжилт олгосон ч хөрөнгийг хүлээж аваагүй 9 байгууллага 90.6 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 5737.6 сая төгрөг зээлийн авлага байгаа бөгөөд үүний 35.9 хувь нь буюу 2038.7 сая төгрөг нь “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК буюу жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээлийн авлага, 64.1 хувь буюу 3636.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагууд байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 8. Зээлийн авлага /сая төгрөг/

Байгууллагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Сум хөгжүүлэх сан	3984.2	3636.9	-347.3
“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	1476.5	2038.7	562.2
Дүн	5460.7	5675.6	214.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2020 оны эцэст 3636.9 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахалтай холбоотой сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн бизнесийн үйл ажиллагаа зогсож зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй байгаа тул ТТЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх, заасан хугацаанд төлөөгүй иргэн, аж ахуйн нэгжийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлсэн болно.

Сум хөгжүүлэх сангийн авлагын эхний үлдэгдэл 3924.2 сая, эцсийн үлдэгдэл 3636.9 сая болж 287.3 сая төгрөгөөр буурсан ба Баянхонгор сум хамгийн өндөр, Баянговь сум хамгийн бага авлагатай байна.

Хүснэгт 9. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага /сая төгрөг/

№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	д.д	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага
1	Баянбулаг	191.6	11	Баян-Өндөр	157.6
2	Баянговь	79.0	12	Галуут	200.7
3	Богд	129.5	13	Гурванбулаг	162.2
4	Баянлиг	134.4	14	Жаргалант	190.8
5	Баян-Овоо	159.3	15	Жинст	131.9
6	Бөмбөгөр	159.5	16	Заг	126.7
7	Бууцагаан	213.0	17	Хүрээмарал	183.7
8	Баянхонгор	563.4	18	Шинэжинст	176.1
9	Баацагаан	233.5	19	Эрдэнэцогт	126.1
10	Баянцагаан	197.3	20	Өлзийт	120.5
НИЙТ ДҮН					3636.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй авлага өмнөх оноос 18.7 сая төгрөгөөр нэмэгдэж 854.9 сая төгрөг байгаа ба нийт авлагын 49.0 хувь буюу 419.1 сая төгрөгийн авлага нь малжуулахын авлага, 29.5 хувь буюу 252.3 сая төгрөгийн авлага нь зураг төсвийн үнэд шилжүүлсэн санхүүжилт байна.

Хүснэгт 10. ОНХС-ийн авлага /сая төгрөг/

Сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эцсийн үлдэгдлийн бүтэц				
				Зураг төсвийн үнэ	Малжуул-ах зээлийн авлага	Хөрөнгө, материал бэлтгэх олгосон урьдчилгаа	Өвс тэжээл	Бусад
Баянхонгор аймаг	238.5	194.3	(44.2)	194.3	-	-	-	-
Баян-овоо	16.9	17.1	0.2	-	17.1	-	-	-
Эрдэнэцогт	1.6	1.6	-	-	-	-	-	1.6
Богд	46.4	55.0	8.6	50.0	-	-	5.0	-
Баянлиг	20.3	6.3	(14.0)	-	6.3	-	-	-
Баянговь	50.8	178.3	127.5	-	37.8	140.5	-	-
Гурванбулаг	0.2	136.6	136.4	-	129.0	-	7.6	-
Заг	3.1	0.2	(2.9)	-	-	-	-	0.2
Баацагаан	96.1	109.7	13.6	-	92.5	-	17.2	-
Өлзийт	200.4	7.6	(192.8)	-	-	-	-	7.6
Хүрээмарал	78.2	76.5	(1.7)	-	76.5	-	-	-
Баян-өндөр	68	68.0	-	8.0	60.0	-	-	-
Баянхонгор сум	0	3.8	3.8	-	-	-	-	3.8
Шинэжинст сум	15.7		(15.7)					
Дүн	836.2	854.9	18.7	252.3	419.1	140.5	29.8	13.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 215.5 сая, эцсийн үлдэгдэл 186.4 сая төгрөг болж, өмнөх оноос 29.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	204.4	185.4	-19	99.5
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9.0			0.0
Цалингийн урьдчилгаа	2.1	1		0.5
Урьдчилж гарсан зардал				0.0
Дүн	215.5	186.4	-19	100
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	11.1	1	-10.1	0.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	204.4	185.4	-19	99.5
Дүн	215.5	186.4	-29.1	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэгдсэн 186.4 сая төгрөгийн үлдэгдлээс 185.4 сая төгрөг нь “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бүртгэгдсэн цахилгааны урьдчилгаа төлбөрийн орлого 6.5 сая, 2020 онд төлөвлөгдсөн дутуу хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын урьдчилж гарсан зардал болох 94.1 сая, ААНОАТ, НӨАТ-ын илүү төлөлт 74.1 сая, хөдөлмөр хамгааллын хувцасны зардал худалдан авахаар төлсөн 10.7 сая төгрөг бүртгэгдсэн байна. .

3.5.5 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 8741.3 сая төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэл 10176.4 сая төгрөг болж, 16.4 хувиар буюу 1435.0 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1318.0 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 1770.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3245.9 сая төгрөг болж 1475.1 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хэрэгжсэн ажлуудын олгосон санхүүжилт 1133.7 сая, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хөрөнгөд тайлант онд гэрээгээр гүйцэтгүүлсэн Өргөөтийн рашааны тохижилт, Оготнотой булгийн тохижилт, Баянхонгор сумын айл өрхүүдэд Эко ариун цэврийн байгууламж барих ажлуудын 123.4 сая, Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн гадна фасадын засварын 92.9 сая төгрөгийг бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 12. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	1,435.2	1,779.8	344.5	13.3
Эм боох материал	53.6	197.4	143.7	1.5
Дуусаагүй үйлдвэрлэл	436.0	193.5	(242.6)	1.4
Бэлэн бүтээгдэхүүн	29.4	37.2	7.8	0.3
Бичиг хэргийн материал	202.6	210.3	7.6	1.6
Аж ахуйн материал	3,182.2	3,134.8	(47.4)	23.4
Сэлбэг хэрэгсэл	27.1	34.6	7.5	0.3
Түлш, шатах тослох материал	51.3	62.4	11.1	0.5
Барилгын засварын материал	133.5	167.8	34.2	1.2
Хүнсний материал	112.7	30.1	(82.6)	0.2
Бусад хангамжийн материал	2,818.7	4,136.8	1,318.0	30.8
Мал амьтад	258.7	191.8	(66.9)	1.4
Бараа материалын дүн	8,741.3	10,176.4	1,435.0	75.8
Нөөцийн бараа	1,770.8	3,245.9	1,475.1	24.2
НИЙТ ДҮН	10512.2	13,422.3	2,910.1	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсөвт байгууллагуудын тусгай зориулалтын материал 344.5 сая, эм боох материал 143.7 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөнтэй холбоотой байгаа бол бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 1318.0 сая төгрөгөөр

өссөнд Сум дундын ойн ангийн 912.4 сая төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэл, Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд 110.0 сая төгрөгийн спорт заалны барилгад аймгийн ОНХС-аас олгосон санхүүжилтийг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.


Нийт бараа материалын үлдэгдлийн 96.9 хувийг төсөвт байгууллага, 3.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Бараа материалын хөдлөл өөрчлөлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Эхний үлдэгдэл	8,508.1	10,512.2	2,004.1
<i>Нэмэгдсэн</i>	14,779.0	13,327.9	(1,451.1)
Худалдан авсан	13,128.2	11,822.5	(1,305.7)
Хандиваар	429.2	373.5	(55.7)
Шилжүүлэн авсан	872.8	707.8	(165.0)
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	2.3	0	(2.3)
Бусад	346.5	424.0	77.5
<i>Хасагдсан</i>	12,774.9	10,417.8	(2,357.1)
Худалдсан, зарцуулсан	10,185.8	9,125.0	(1,060.8)
Шилжүүлсэн	1,260.3	698.4	(561.9)
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	902.1	0.2	(901.9)
Бусад /Акталсан/	426.8	594.2	167.4
Эцсийн үлдэгдэл	10,512.1	13,422.3	2,910.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	9,660.7	13,004.2	3,343.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	851.4	418.0	(433.4)
Дүн	10,512.1	13,422.3	2,910.2

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 11822.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 373.5 сая, балансаас баланст 1131.8 сая төгрөгийн шилжүүлэн авч, нийт 13327.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 9125.0 сая төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 698.6 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 594.2 сая төгрөгийн бараа материалыг акталж нийт 10417.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд бараа материалыг анхан шатны баримтаар үнэн зөв, ангилан бүртгэл хөтөлдөггүй, бараа материалын шинж чанаргүй нэг удаагийн зардлыг орлогоор авч зарлагаддаг, тооллого тооцоог хийж баталгаажуулаагүй, шийдвэр гаргаагүйгээр акталж данснаас хасдаг, оны эцэст их хэмжээгээр худалдан авалт хийж нөөц үүсгэсэн зэргээр бараа материалын данстай холбоотой нийт 706.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.



Тухайлбал:

- Баянбулаг сумын ЗДТГ, Баянговь сумын ЭМТ, ЕБС, Баянлиг сумын ЕБС, Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг, Бөмбөгөр сумын ЕБС, ЗДТГ, Бууцагаан сумын ЗДТГ, Галуут сумын цэцэрлэг, Гурванбулаг сумын ЭМТ, Хүрээмарал сумын ЕБС, ЭМТ, Шинэжинст сумын ЭМТ, ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЕБС, Наранмандал, Энхбүрд, Оточ мандал, Оточ номгон өрхийн эмнэлгүүд зэрэг 19 байгууллага бараа материалын тайланг сар бүр анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв гаргаагүй;
- Баянбулаг сумын ЗДТГ, Баянхонгор аймгийн Нийтийн номын сан, Баянхонгор сумын 11, 15 дугаар цэцэрлэг, Бөмбөгөр сумын ЕБС, Жинст сумын ЕБС, Өлзийт сумын ЗДТГ, "Чандмань -

Баянхонгор” ХХК зэрэг 8 байгууллага жилийн эцэст хөрөнгийн тооллогыг иж бүрэн хийж баталгаажуулаагүй;

- Баянбулаг, Баянлиг, Баян-Овоо, Баянхонгор, Баянцагаан, Бууцагаан, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Өлзийт, Шинэжинст сумдын болон аймгийн ЗДТГ нь Сум дундын ойн ангиас нийлүүлсэн өвс тэжээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан данс бүртгэлд бүрэн тусгаагүй;

- Баянцагаан сумын ЗДТГ, Бөмбөгөөр сумын ЕБС, Жинст сумын ЗДТГ нь хөрөнгө актлах тухай удирдлагын шийдвэр гараагүй байхад нийт 32.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлаж данснаас хассан;

- Гурванбулаг сумын ЭМТ, Жинст сумын ЗДТГ нь оны эцэст нийт 11.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг худалдан авч нөөц үүсгэсэн;

- Баянговь сумын ЕБС, Баянлиг сумын цэцэрлэг, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар, “Тохижилт үйлчилгээ” ОНТҮГ, Хүүхдийн Тэмүүжин театр, Баянхонгор сумын 10, 11, 5 дугаар цэцэрлэг, Бууцагаан сумын ЗДТГ, ЭМТ, Гурванбулаг сумын ЭМТ, Жинст сумын ЗДТГ, Заг сумын ЕБС, ЗДТГ, Өлзийт сумын цэцэрлэг, Хүрээмарал сумын цэцэрлэг, Эрдэнэцогт сумын цэцэрлэг, ЭМТ зэрэг 21 байгууллага 84.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Санхүүгийн тайланд бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлагыг холбогдох хууль, журмын дагуу зах зээлийн ханшаар үнэлж бүртгэн, оны эцэст малын тоог А дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлж байх” зөвлөмжийг өгсөн ч зөвлөмж хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

• Төсөвт байгууллагууд хөрөнгөд бүртгэлтэй малын нас дэвшилтийн хөдөлгөөнийг бүртгээгүй, туслах аж ахуйн орлогыг дансанд бүрэн оруулаагүй, малын тоог А дансаар баталгаажуулах байдал хангалтгүй байна. Аудитаар мал амьтны бүртгэлтэй төсөвт байгууллагуудыг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авсан бүртгэлтэй тулган шалгахад Баянговь, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдын ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЭМТ, Баянхонгор аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын дансанд бүртгэлтэй мал статистикийн хэлтэст байгууллагын нэр дээр бүртгээгүй, мөн Баянбулаг сумын ЗДТГ, Баянцагаан сумын ЭМТ, Бууцагаан сумын “Баян”, “Баянбүрд”, “Наран” багийн нэр дээр нийт 311 толгой мал бүртгэлтэй байгаа ч тус байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.

Иймд цаашид санхүүгийн тайланд бүртгэлгүй малыг холбогдох стандартын дагуу үнэлж бүртгэх, бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлага малын тоог “А” дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 242758.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 275576.2 сая төгрөг болж 32817.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 26220.0 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн 94.0 хувийг биет хөрөнгө, 6.0 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 17714.9 сая төгрөг болж өмнөх оноос 8707.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 1.3 хувийг программ хангамж, 98.7 хувийг газар буюу бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 14. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Барилга байгууламж, орон сууц	178,666.7	196,207.0	17,540.3	71.2
Тээврийн хэрэгсэл	8,307.4	8,731.9	424.5	3.2
Машин тоног төхөөрөмж	18,484.0	21,875.6	3,391.6	7.9
Тавилга эд хогшил	8,239.1	9,234.7	995.6	3.4
Зам гүүрний барилга байгууламж	965.5	846.5	(119.0)	0.3
Түүх соёлын дурсгалт зүйл	963.7	963.7	-	0.3
Дуусаагүй барилга байгууламж	1,513.3	1,565.5	52.2	0.6
Номын фонд	942.5	1,006.6	64.1	0.4
Бусад үндсэн хөрөнгө	15,669.3	17,429.8	1,760.5	6.3

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Программ хангамж	317.1	238.6	(78.5)	0.1
Бусад биет бус хөрөнгө	8,690.0	17,476.3	8,786.3	6.3
Дүн	242,758.6	275,576.2	32,817.5	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2824.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 19960.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст, 9.0 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 736.6 сая төгрөгийг хандиваар авч, бусад хэлбэрээр 13500.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэн нийт 37024.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 4206.7 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 1638.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 1855.8 сая төгрөгийн хөрөнгийг актлан, 14.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулж, бүтцийн өөрчлөлтөөр 305.3 сая төгрөгийн хөрөнгө, шилжүүлж, бусад хэлбэрээр 392.7 сая төгрөг төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Хүснэгт 15. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Биет хөрөнгийн дүн	Биет бус хөрөнгийн дүн	Нийт хөрөнгийн дүн
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	233,751.5	9,007.1	242,758.6
Нэмэгдсэн	28,200.9	8,823.3	37,024.2
Худалдан авсан	2,735.2	82.9	2,818.1
Хандиваар	718.7	17.9	736.6
Шилжүүлэн авсан	19,957.8	2.5	19,960.3
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	9.0	-	9.0
Бусад	4,780.2	8,720.0	13,500.2
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-
Хасагдсан	4,091.1	115.5	4,206.7
Худалдсан	14.5	-	14.5
Акталсан	1,752.8	103.0	1,855.8
Шилжүүлсэн	1,637.9	0.6	1,638.5
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	293.7	11.6	305.3
Бусад	392.2	0.5	392.7
Дахин үнэлгээний хорогдол	-	-	-
Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	257,861.3	17,714.9	275,576.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн бусад хэсэгт нэмэгдсэн 13499.4 сая төгрөг нь Хот тохижилт үйлчилгээний газрын 7696.3 сая төгрөгийн газар, 666.9 сая төгрөгийн ойн зурвас дахь мод, бут болон аймгийн төвийн булаг шандын хайс хамгаалалтын хашаа зэргийг орлого авсан, аймгийн Биеийн тамир спортын газар 925.7 сая төгрөгийн газар, 110.1 сая төгрөгийн зам гүүрний барилга байгууламж, 486.3 сая төгрөгийн барилга байгууламжийг бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн бусад хэсэгт хасагдсан 147.6 сая төгрөг нь аймгийн Биеийн тамир спортын газрын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны хоргодол 127.0 сая төгрөгийг бүртгэснээс шалтгаалсан байна.

Дуусаагүй барилга дансанд өмнөх онд 8 байгууллагын 1513.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэйгээс тайлант онд 2 байгууллагын 70.0 сая төгрөгийн дуусаагүй барилга нэмэгдэж, 2 байгууллага 17.8 сая төгрөгийн дуусаагүй барилгыг ашиглалтад хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, оны эцэст 8 байгууллагын 1565.5 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байна.

Энэ нь Биеийн тамир спортын газрын усан бассейн спорт цогцолборын барилгын суурийн хэсэг болох 809.9 сая, Баян-Овоо хуучин спорт заалны барилга 5.8 сая, Бууцагаан сумын бага сургуулийн барилгын суурь 316.8 сая, соёлын төвийн барилгын суурь болох 205.0 сая, Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн цэвэр бохир усны шугам 10.0 сая, Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн тоглоомын талбай 20.0 сая, Заг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ахмадын өргөө 198.1 сая төгрөг, Өлзийт сумд төсвийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн тоглоом, Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн зэргийг дуусаагүй барилгад бүртгэсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар эд хөрөнгийн тооллогоор үрэгдсэн, байхгүй хөрөнгийг тоолсноор бүртгэж дутагдсан хөрөнгүүдийн эзэн холбогдогчийг тогтоож төсөвт учирсан хохирлыг барагдуулаагүй, үндсэн хөрөнгийг ашиглах жилийг программд “-1”, “0”, “2019” гэх мэтээр буруу оруулснаас тайлант жилийн элэгдлийн зардал буруу илэрхийлэгдсэн, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн, эргэлтийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

Тухайлбал:

- Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Биеийн тамир спортын газар нь үндсэн хөрөнгийн ашиглах жилүүдийг программд оруулаагүйгээс элэгдэл бодогдоогүй;
- Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль, Баян-Овоо сумын ЗДТГ, Хот тохижилт үйлчилгээний газар, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв, Өлзийт сумын ЗДТГ, Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль, Эрдэнэцогт сумын Цэцэрлэг, Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь тооллогын бүртгэл ирүүлээгүй, тооллогын бүртгэлд хөрөнгө орхигдуулж тоолсон, хөрөнгийг орлого аваагүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд бүртгэсэн;
- Баянлиг сумын ЗДТГ, Баацагаан сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЗДТГ нь аймгийн Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрлээ.

Монгол улсын Засгийн газраас төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглан байнгын цахилгаанаар хангах “Буман нарны гэрэл” төслийн хүрээнд Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдад 2007 онд хэрэгжүүлсэн “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг сумдын ЗДТГ-ын хөрөнгөд тус тус 920.0 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Тус сумд нь 2014 онд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон бөгөөд “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийн гол эд анги нь ажиллахгүй, сэнс толь эд анги нь хэмхэрч үгүй болсон байхад сумдын ЗДТГ-ын хөрөнгө тус бүрийн нэр төрөл, үнийн задаргаа гаргаагүй нийт дүнгээр 920.0 сая төгрөгөөр бүртгэлтэй хэвээр байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх “Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад хөрөнгийн ашиглалтын талаар холбогдох тухайн сумдаас тайлбар тодруулга авахад:

- **Баянцагаан:** “Тус сумын сэргээгдэх эрчим хүч нь 2007 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 920.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр баригдсан ба 240ш нарны толь, 12ш сэнстэй байсан. Ашиглалтын явцад салхи шуурганы нөлөөнөөс 12 сэнс нь хугарч бутарч унаж ашиглах боломжгүй болсон ба 12ш сэнсний хөлийг сумын төвийн гэрэлтүүлгийн цамхаг гэрлийн хөл болгон ашиглаж байна.

Нийт 240ш нарны толь байснаас “Гичгэнэ”, “Дэлгэрэх”, “Цэцэн” багийн төвд тус бүр 24ш толь, 1ш инвертер, нийт 72ш толь, 3ш инвертерийг суурилуулсан. Мөн хөдөөгийн багийн 4 худагт тус бүр 12ш толь, 1ш инвертер нийт 48 ш инвертерийг суурилуулсан одоо ашиглагдаж байгаа. Үлдсэн 120ш толийг ЗДТГ-ын агуулахад буулгаж хадгалсан ба дийлэнх хэсэг нь хагарч ашиглах боломжгүй болсон, мөн толины станц инвертерийг ЗДТГ-ын арын хашаанд буулгасан”;

- **Баян-Өндөр** “Тус суманд ашиглагдаж байсан сэргээгдэх эрчим хүчний цогцолборын салхин сэнс бүгд эвдэрсэн бөгөөд нарны цахилгаан үүсвэр /150-толь, 150-аккумулятор/-ийг Идрэн 4 дүгээр багийн төвийн хэрэгцээнд 2014 онд шилжүүлэн одоог хүртэл ашиглаж байгаа”;

- **Шинэжинст** “Тус сумын ЗДТГ-ын барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй сэргээгдэх эрчим хүч нь 920.0 сая төгрөгийн өртөгтэй бүртгэгдсэн байдаг. Одоогийн байдлаар манай сумын нутаг дэвсгэрт байрладаг “Цагаан богд”-ын застаанд 30ш толь, инвертер өсгөгч 1ш ашиглагдаж байна. Мөн “Эхэн хавцгайд” багийн эхийн гол төвд 80ш толь ашиглагдаж байна. Үлдэгдэл 8ш толь

нь агуулахад хураасан байна. Аккумуляторууд нь бүгд ашиглагдах болж устгагдсан, зэвснүүд нь бүгд салхинд хуарч ашиглах боломжгүй болсон” гэсэн тайлбарыг тус тус албан бичгээр ирүүлсэн болно.

Дээрх сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудын хөрөнгөөс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул хөрөнгийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт


Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 9827.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11293.3 сая төгрөг болж, 1466.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнээс богино хугацаат өр төлбөр 3641.9 сая төгрөг болж өмнөх оноос 681.5 сая төгрөгөөр өссөн нь урьд оны хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, урьдчилж орсон орлого 51.7 сая төгрөгөөр өссөн ба нийт өр төлбөрийн 32.2 хувийг богино хугацаат өр төлбөр, 67.8 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙГ БҮТЦЭЭР НЬ ХАРЬЦУУЛБАЛ



Хүснэгт № 16. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), бууралт (-)	Хувь
Богино хугацаат өр төлбөр	2,960.4	3,641.9	681.5	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	32.9	47.0	14.1	1.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	814.8	229.9	(584.9)	5.2
Байгууллагад өгөх өглөг	1,894.2	3,019.2	1,125.0	68.1
Хувь хүмүүст өгөх өглөг	15.8	99.9	84.1	2.3
Татварын өглөг /ТӨҮГ/	126.9	124.5	(2.4)	2.8
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	-	-	-
Дансны өглөг /ТӨҮГ/	6.9	0.8	(6.1)	0.0
Урьдчилж олсон орлого	68.9	120.6	51.7	2.7
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,866.7	7,651.5	784.8	100.0
Төгрөг	6,057.7	7,065.8	1,008.1	92.3
Хувь хүмүүсийн зээл	1,077.4	2,111.9	1,034.5	
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	4,980.3	4,953.9	(26.4)	
Гадаад валют	809.0	585.7	(223.3)	7.7
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	809.0	585.7	(223.3)	
Нийт өр төлбөрийн дүн	9,827.1	11,293.3	1,466.3	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр:				
Богино хугацаат өр төлбөр дүн	2,960.4	3,641.9	681.5	32.2
Төсөвт байгууллага	429.7	1,094.0	664.3	24.7
Төсөл/сан	1,554.5	2,156.9	602.5	48.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	976.3	390.9	(585.3)	8.8
Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,866.7	7,651.5	784.8	67.8
Төсөвт байгууллага	4,818.2	4,818.2	0.0	63.0
Төсөл/сан	-	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,048.4	2,833.2	784.8	37.0
Нийт өр төлбөрийн дүн	9,827.1	11,293.3	1,466.3	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 24.7 хувь буюу 1094.0 сая төгрөгийн өглөг нь төсөвт байгууллагын, 66.5 хувь буюу 2156.9 сая төгрөг нь техник хяналт, барьцаа данс,

8.8 хувь буюу 390.9 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын өр төлбөр байна.

Техник хяналт, барьцаа дансны өглөгийн үлдэгдлийн 1704.7 сая төгрөг нь 2019-2020 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн чанарын баталгааны барьцаа, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 4 төсөл, арга хэмжээний дутуу санхүүжилт болох 288.0 сая, зохиогчийн хяналтын зардлын үлдэгдэл 102.9 сая, 2017 онд 7 аж ахуйн нэгжийн уул уурхайн нөхөн сэргээлтийн 61.3 сая төгрөгийн барьцаа тус тус бүртгэлтэй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба оны эхэнд 3 ОНӨААН-тэй холбоотой 68.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байснаас тайланд онд 0.3 сая төгрөгийн орлого барагдаж, нэмж 52.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэгдэж, оны эцэст 120.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Тайлант оны эдгээр урьдчилж орсон орлого нь “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-д 12.8 сая, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д хяналтын зардлын 101.4 сая, түрээсийн барьцаа 6.3 сая төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба оны эхэнд 3 ОНӨААН-тэй холбоотой 68.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байснаас тайланд онд 0.3 сая төгрөгийн орлого барагдаж, нэмж 52.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэгдэж, оны эцэст 120.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн өмнөх онуудад үүссэн олон жилийн насжилттай авлага, өглөгийг барагдуулдаггүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай батлагдсан маягтын дагуу тооцоо нийлж, баталгаажуулдаггүй, цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлдэггүй, даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс авлага, өглөг үүссэн байхад залруулга хийдэггүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн байна.

Тухайлбал:

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль, Баян-Өндөр сумын ЗДТГ, 10-р цэцэрлэг, Жаргалант сумын ЗДТГ, Хүрээмарал сумын Цэцэрлэг, Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв, Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль, Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв, нь санхүүгийн тайланд байгууллагад өгөх болон ажилчидтай холбоотой өглөгийг дутуу тусгасан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 88 дугаар тогтоолоор “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсны дагуу хаалтын баланс гаргаж тус байгууллагуудын балансад бүртгэлтэй “Тариалан эрхлэлтийг дэмжих” санд төлөх 200.0 сая төгрөгийн өглөгийг аймгийн Сум дундын ойн ангийн балансад шилжүүлж бүртгэсэн байна.

Тус өглөг нь 2017.09.05-нд аймгийн Засаг дарга Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сантай “Санхүүгийн дамжуулах түрээсийн гэрээ” байгуулан нийт 80170.8 ам.долларын буюу 200.0 сая төгрөгийн газар тариалангийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг жилийн 5.6%-ийн хүүтэй, 2 сарын хугацаатай төлбөрийг 2017.11.01-нд төлж дуусгах нөхцөлтэйгөөр зээлээр худалдан авч үүссэн ба төлбөр төлөгдөөгүй, гэрээний хугацаа дуусаж хугацаа хэтэрсэн байна.

Иймд тус өглөгийг түрээслүүлэгч тал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан төлбөрийг төлөх эсэх талаар шийдвэр гаргуулан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 6866.6 сая төгрөг байсан ба тайлант онд 1034.5 сая төгрөгийн өглөг шинээр нэмэгдэж, 249.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулж оны эцэст 7651.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 17. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг/

Байгууллагын нэр	Зээлийн эх үүсвэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн гүйлгээний дүн	Хорогдсон гүйлгээний дүн	Эцсийн үлдэгдэл
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР					
Урт хугацаат зээл		6,866.6	1,034.4	249.6	7,651.4
Төгрөг		6,057.6	1034.4	26.3	7,065.7
Чандмань Баянхонгор ХК	Чандмань Баянхонгор ХК МОН-1847	89.3		5.0	84.3
	Хас банкны зээл	72.7		21.3	51.3
Аймгийн ОНӨГ	Чандмань Баянхонгор ХК МОН-2301	4,818.2			4,818.2
"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	560.0	976.8		1,557.4
	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	450.0			429.5
	Төрийн сан /Ангилалдаагүй зардал-жимс жимсгэнэ тариалах/	50.0			50.0
	Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт	17.4	57.6		75.0
Гадаад валют		809.0	0.0	223.3	585.7
"Баянхонгор - Эрчим хүч" ЦТХХК	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-МОН-1847	23.3	-	4.0	19.3
	"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-МОН-3500	785.7		219.3	566.4

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн 249.7 сая төгрөгөөр буурсан нь "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй МОН-1847 зээлээс 4.0 сая, Дэлхийн банкны санхүүжилтээр олгосон МОН-3500 зээлээс 219.3 сая төгрөг, Чандмань Баянхонгор ХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олгосон МОН-1847 зээлээс 5.0 сая төгрөгийг тус тус төлсөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 18. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг/

Байгууллага	2019 оны үлдэгдэл	2020 оны үлдэгдэл	Гэрээний огноо	Үндсэн төлбөр эхлэх хугацаа	Үндсэн төлбөр дуусах хугацаа	Хугацаа хэтэрсэн/үндсэн төлбөр/	Хугацаа хэтэрсэн/хүү	Үлдэгдэл	
								Баталгаа жуулсан	Баталгаа жуулаагүй
1. Гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн									
А.Азийн хөгжлийн банк									
Чандмань Баянхонгор ХК МОН-1847	89.3	84.3	2007.06.16	2012.05.30	2025.11.30		7.1	1.3	84.3
"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-МОН-3500	23.3	19.3	2006.04.19	2012.05.30	2025.11.30				19.3
Чандмань Баянхонгор ХК МОН-2301	4818.2								0
Орон нутгийн өмчийн газар		4818.2							4818.2
Дүн	4930.8	4921.8	0	0	0	7.1	1.3	19.3	4902.5
Б. Дэлхийн банк									
"Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-МОН-3500	785.7	566.4	2006.11.27	2012.10.01	2036.10.01				566.4
Дүн	785.7	566.4							0
Нийт гадаад эх үүсвэрээс авсан зээлийн дүн	5716.5	5488.2						566.4	4902.5
2. Дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн									
Чандмань Баянхонгор ХК	72.8	51.3							51.3
Хас банк	72.8	51.3	2018.05.17	2018.06.25	2023.05.25		0	0	51.3
"Баянхонгор үйлдвэржилт Хөгжлийн корпораци"ХХК	1077.4	2111.9		0.0	0.0	0.0	0.0	2111.9	0.0
Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	560	1,557.4	2017.06.28						1,557.4
Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	450	429.5	2018.04.20						429.5
Төрийн сан /Ангилалдаагүй зардал-жимс жимсгэнэ тариалах/	50	50.0	2019						50.0
Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт	17.4	75.0							75.0
Нийт дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн	1150.2	2163.2					0.0	0	2163.2
Нийт зээлийн дүн	6866.7	7651.4					0.0	0.0	2729.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-д орон нутгийн санхүүжилтээс 480.0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэр, аймгийн орон нутгийн төсвөөс зээлийн батлан даалтын сангаас 2019 онд шилжүүлсэн 50.0 сая, 2016-2020 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн 429.4 сая төгрөг, аймгийн орон нутгийн орлогоос Хас банкаар дамжуулан олгож байсан ЖДҮ-ийн зээлийн барьцаа дансны үлдэгдэл шилжүүлсэн 75.0 сая төгрөгийг тухайн байгууллагад зээл олгох эх үүсвэрээр олгож, нийт урт хугацаа өр төлбөрийн данс, нийт 1034.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна

“Чандмань Баянхонгор” ХК-ийн 2012-2014 оны хооронд хэрэгжсэн Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөлтэй холбоотой 4818.2 сая төгрөгийн зээлийг аймгийн ОНӨГ-Т 2019 онд шилжүүлэн бүртгэсэн байна.

Дээрх урт хугацаат зээлтэй холбоотойгоор Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Тус урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих” зөвлөмжийг өгсөн хэдий ч биелүүлж ажиллаагүй тул Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10⁴ дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлэв.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 209538.4 сая, эцсийн үлдэгдэл 235633.9 сая төгрөг болж, өмнөх оноос 26095.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 19. Хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	77,747.4	93,143.2	15,395.8	39.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,537.1	61,030.1	(1,507.0)	25.9
Хуримтлагдсан үр дүн	69,253.8	70,962.0	1,708.2	30.1
Тайлант үеийн үр дүн		10,498.5	10,498.5	4.5
Дүн	209,538.4	235,633.9	26,095.6	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	180,766.10	200,201.50	19,435.4	85.0
Төсөл/ сан	1,588.65	843.3	(745.3)	0.4
Төрийн сан	2,400.40	3,610.60	1,210.2	1.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	24,783.20	30,978.50	6,195.3	13.1
Дүн	209,538.40	235,633.90	26,095.55	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Засгийн газрын оруулсан капитал данс нь үндсэн хөрөнгийн өсөлтийн 15395.8 сая төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хассанаас 1507.0 сая төгрөгөөр дахин үнэлгээний нөөц данс буурсан ба тайлант үеийн үр дүн 10498.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Бодлогын өөрчлөлт алдааны залруулгын данс дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталсан, үндсэн хөрөнгийг үлдэгдэл залруулсан, өмнөх оны үндсэн хөрөнгийн элэгдэл, өглөг, авлагыг зөрүүтэй тооцсон зэргээр 1708.2 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл дахин үнэлгээний дэлгэрэнгүй бүртгэлээс 3409.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 20. Хөрөнгийн дахин үнэлгээ зөрүүтэй илэрхийлэгдсэн байгууллагууд /сая төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангаар	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, журналаар	Зөрүү
Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургууль	1,007.5	547.7	459.8
Баянбулаг сумын Цэцэрлэг	184.4	75.3	109.1
Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв	69.6	12.3	57.3
Баянлиг сумын ЗДТГ	85.7	69.8	15.9
Баянлиг сумын Цэцэрлэг	221.7	250.4	(28.7)
Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль	374.2	99.9	274.3
Баян-Овоо сумын ЗДТГ	313.0	141.6	171.4
Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	166.9	165.1	1.9
Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй, байгалийн музей	846.3	368.5	477.8
Баянхонгор сумын 4-р цэцэрлэг	466.0	1.3	464.7

⁴ Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль	525.3	234.7	290.5
Галуут сумын ЗДТГ	209.0	7.7	201.3
Галуут сумын Эрүүл мэндийн төв	651.3	140.6	510.7
Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв	68.9	9.2	59.7
Жинст сумын ЗДТГ	351.2	7.4	343.9
Эрдэнэцогт сумын ЗДТГ	197.1	197.4	(0.2)
Дүн	5,738.3	2,328.8	3,409.5

Эх сурвалж: Тус байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл

Иймд төсөвт байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр тулган баталгаажуулж 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд зөрчлийг залруулж бүртгэх зөвлөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт

Аймгийн Засаг даргын харьяаны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 7 байгууллагын санхүүгийн тайланд хуримтлагдсан үр дүн -998.1 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 21.ОНӨААН-ийн хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

№	ААН нэр	тоо	Орлого	Зарлага	2019 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Баянхонгор Эрчим хүч ХХК	1	10,152.7	10,147.2	5.5	(504.6)	(499.1)
2	Чандмань Баянхонгор ХК	1	1,848.3	1,977.9	(129.6)	482.4	378.7
3	Цэвэр хот ОНӨҮГГазар	1	585.8	645.7	(59.9)	(358.6)	(418.4)
4	Баянхонгор хайрхан фарм ХХК	1	17.6	-	17.6	(17.6)	-
5	Нью майнинг ХХК	1	-	53.3	(53.3)	53.3	-
6	Хонгор шинэ агро ОНӨААТҮГ	1	148.4	250.3	(101.9)	101.9	-
7	Үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	1	173.1	461.9	(288.7)	(165.0)	(453.7)
8	Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба	1	45.6	51.2	(5.6)	-	(5.6)
	ДҮН	8	12,971.6	13,587.4	(615.7)	(408.2)	(998.1)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 10 байгууллага 70.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 100 байгууллага 3493.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 61 байгууллага 3354.7 сая, нийт 6917.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 81 байгууллага 4277.3 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 2 байгууллага 596.3 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө тэтгэмжид 23 байгууллага 598.9 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 60 байгууллага 919.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд нэг байгууллага 5.0 сая, хөрөнгийн зардалд 2 байгууллага 6.0 сая нийт 6402.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 515.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 596.3 сая төгрөг олгосон нь аймгийн ИТХ-ын нэмэлт дансаар 562.0 сая төгрөгийг хэлмэгдэгсдийн ар гэрт олгосон цагаатгалын нөхөн төлбөрт, Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн албан хаагчийн ар гэрт 34.3 сая төгрөгийн тэтгэмж олгосонтой холбоотой байна.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад нийт 919.1 сая төгрөг олгосныг байгууллагын төрлөөр нь авч үзвэл эрүүл мэндийн салбарын албан хаагчдад 178.2 сая, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдад 577.4 сая,

сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдад 163.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 93 мэдээллийг хугацаанд нь, 59 мэдээллийг хугацаа хоцроож, хагас жилийн санхүүгийн тайлан, бүтэн жилээр байршуулах аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй байна.

Хүснэгт 22. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	7	1	Дараа жилийн төсвийн төсөл,
2	Хагас жил	3	3	1	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
3	Улирал бүр	2	8	6	2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-3, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл-1,
4	Сар бүр	5	60	16	44	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл-1,2,3,4,5,6,8,10,11,12-р сарууд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-1,4,5,6,7,8,9,10,11,12-р сарууд, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл-2,4,10,12, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл-1,2,3,4,5,6,8,10,11,12-р сарууд, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл-1,2,3,4,5,6,8,10,11,12-р сарууд
5	Тухай бүр	6	72	61	11	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт-3,5,9,11,12-р сарууд, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг - 2,3,4-р сарууд, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр-3,4-р сарууд, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт-10 сар
НИЙТ		28	155	91	59	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 179 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа 7 хувийн цэцэрлэг, 2 хувийн сургууль, 4 өрхийн эмнэлэг, ахмадын хороо, нийт 198 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа, ТШЗ-ийн болон ТТЗ, ОНӨААН-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг авч үзсэн болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 үйлчлэлд хамаарах нийт 179 байгууллагын шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих 27109 мэдээллээс 1173.0 сая төгрөгийн 257 мэдээллийг мэдээлээгүй, 9431.6 сая төгрөгийн 2196 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд уг зөрчлийг арилгах 23 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 110 зөвлөмж хүргүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 үйлчлэлд хамаарах нийт 5 байгууллагын шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих 581 мэдээллээс 9 мэдээллийг мэдээлээгүй, 325.5 сая төгрөгийн 120 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд уг зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 3.1.5-т хамаарах нийт 14 байгууллагын шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих 53 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 772.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 529.1 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, “Баянхонгор Нью майнинг” ХХК нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага өгч, 243.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 13 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд гаргаж төрийн аудитын байгууллагад ирүүлж, 8 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан хэдий ч зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнд ахиц гараагүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийн тоо нэмэгдсэн, алдаа зөрчил давтагдсан зэргээс шалтгаалж зөвлөмжийн хэрэгжилт 67.0 хувьтай байна.

Хүснэгт 23. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
1	Сумдын төсөвт байгууллагын төсвийн захирагч нарийн Төсвийн тухай хууль тогтоомж дүрэм журмын талаарх мэдлэгийг дээшлүүлэх болон санхүүгийн ажилтнуудыг чадваржуулах, ажлын байрны сургалтыг зохион байгуулж, мэргэжил, үр чадварын түвшин тогтоох шалгалт тогтмол авч, арга зүйгээр хангаж ажиллах.	Сумдын санхүүгийн ажилтнуудын сургалтыг тухайн цаг үеийн нөхцөл байдалд уялдуулж сумдыг хоёр хоёроор нь бүсчлэн төсөвт байгууллагын 95 нягтлан бодогч, 76 нярвуудыг хамруулан сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг 5-р сард багтааж 1-р улирлын санхүүгийн тайлан гаргуулан алдаа дутагдлыг гаргаж буй нөхцөлийг тодруулан тайлбарлаж залруулга хийлгэж дадлагажуулан аймгийн Засаг даргын 127 дугаар захирамжийн дагуу санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг баталгаажуулан цаг хугацаанд нь мэдээ тайлан, бүртгэл хөтлөлтийг хийлгэснээр санхүүгийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах ажлыг хийсэн. Мөн ахмад санхүүч мэргэжсэн нягтлан бодогч Д.Цэцэгмаа, О.Мандах нарыг урьж дадлагажуулах сургалтыг хийсэн.	Сумдын төсөвт байгууллагын төсвийн захирагч нарийн Төсвийн тухай хууль тогтоомж дүрэм журмын талаарх мэдлэгийг дээшлүүлэх болон санхүүгийн ажилтнуудыг чадваржуулах, ажлын байрны сургалтыг зохион байгуулж ажилласан байна. Биелэлт 100%
2	Аймгийн ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон 475.9 сая төгрөгийн зээлийг барагдуулахыг аймгийн ИТХ-аас 2018 онд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д даалгасан шийдвэрт тулгуурлан тус зээлийн авлагыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д шилжүүлэн бүртгэж, төлөгдөөгүй он удаан жил болсон зээлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх.	ЖДҮ-ийн зээлийн 475.9 сая төгрөгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д барагдуулах ажлыг хариуцуулахаар ИТХ-н тогтоолыг гаргуулж зээлийг тухайн байгууллагын 8-р сарын НББ-д шилжүүлэн бүртгэсэн болно.	ЖДҮ-ийн зээлийн 475.9 сая төгрөгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д барагдуулах ажлыг хариуцуулахаар ИТХ-н тогтоолыг гаргуулж зээлийг тухайн байгууллагын 8-р сарын НББ-д шилжүүлэн бүртгүүлсэн байна. Биелэлт 100%
3	Зээлийн батлан даалтын сантай аймгийн Засаг дарга 2017.04.26-ний өдөр байгуулсан 07 тоот гэрээний дагуу аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа боловч барьцаа хөрөнгө багатай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн зээл авах боломжийг нэмэгдүүлж, Зээлийн батлан даалтын сантай хамтарч ажиллах.	Зээлийн батлан даалтын сантай гэрээ байгуулан 50.0 сая төгрөгийг барьцаалан ажиллаж байсан. Тухайн сан нь гэрээний нөхцөлөөр биелүүлээгүйн учраас барьцаа хөрөнгийг эргүүлэн татаж “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”-д олгож жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгох ажлыг дээрх байгууллагад хариуцуулан ажилласан.	Зээлийн батлан даалтын сантай гэрээний дагуу байршуулсан 50,0 сая төгрөгийн хөрөнгийг эргүүлэн татаж “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д олгож жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгох ажлыг дээрх байгууллагад хариуцуулан ажилласан. Биелэлт 100%
4	Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулах, тус ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах.	Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажиллах талаар Бөмбөгөр сумын тамгын газарт нь хариуцуулсан.	Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд 2020 онд нэмж санхүүжилт олгоогүй ба өмнөх онуудад олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулаагүй байна. Биелэлт 0%
5	Өмнөх онуудад сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дуусаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгасан 211.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд дуусгаж, хөрөнгийг орлогод авахад хяналт тавьж ажиллах.	Өмнөх оны дуусаагүй хөрөнгө оруулалтыг хөрөнгийг 1-р улирлын санхүүгийн тайланд зөвлөмжийн дагуу тусгасан болно.	Өмнөх онуудад сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дуусаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгасан 211.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний авлагыг 2020 оны 1-р улирлын санхүүгийн тайланд залруулж бүртгэсэн байна. Биелэлт 100%
6	Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж, шийдвэр гарган санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаж байх.	Тухайн байгууллагын хүсэлтийн дагуу зарцуулагдаагүй үлдэгдэлд 166.2 сая төгрөгийг буцаан олгож журмын дагуу хүсэлт ирүүлээгүй	Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 496.2 сая төгрөгийг үлдэгдлийг төвлөрүүлсэн байгаа ч

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	Аудитаар тооцсон биелэлт
		болон олгох боломжгүй үлдэгдлийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.	авлага, өглөгөөр тусгаж баталгаажуулаагүй байна. Биелэлт 0%
7	Бөмбөгөр сумын ЗДТГ, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайланд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-д төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.	Бөмбөгөр сумын тамгын газартай холбоотой өвсний 9.0 сая төгрөгийн өглөгийг эзнийг нь тодруулан барагдуулан ажилласан байна. /Зөвлөмжид хамааралгүй асуудлыг гаргаж ирүүлсэн/	Бөмбөгөр сумын ОНХС, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайланд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-д төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Биелэлт 0%
8	Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй санал дүгнэлт авсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд илэрсэн зөрчлүүдийг хууль хяналтын байгууллагад нэн даруй шилжүүлж, буруутай этгээдийг тогтоож, авлага өглөгийг бүрэн барагдуулж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах.	ОНӨААН-ийн Хонгор шинэ агро, Нью майнинг байгууллагуудыг санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд санхүүгийн үйл ажиллагаанд нь санхүүгийн хяналт хийлгэн тухайн байгууллагыг татан буулгах талаар Аймгийн ИТХ-д оруулсан болно.	ОНӨААН-ийн Хонгор шинэ агро, Нью майнинг байгууллагуудыг санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд санхүүгийн үйл ажиллагаанд нь санхүүгийн хяналт аудиторын алба хяналт шалгалт хийсэн байна. Биелэлт 100%
9	Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих.	Урт хугацаат зээлийг төлөх талаар 2021 оны аймгийн орон нутгийн төсөвт тусгуулахаар тооцоо судалгаа хийн ажиллаж байна.	Хэрэгжээгүй Биелэлт 0%
10	Сум хөгжүүлэх сангаас олгосон нийт зээлийн 42.6 хувь буюу 1672.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг сумдын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулж, биелэлтийг тооцож ажиллах.	Сум хөгжүүлэх зээлийн төлөлтийг барагдуулах талаар сумын тамгын газарт хариуцуулан биелэлтийг 3-р улирлын тайлангаар тооцож ажиллах болно.	Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахалтай холбоотой сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэдийг бизнесийн үйл ажиллагаа зогсож зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй байгаа ТТЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж хүргүүлсэн. Биелэлт 100%
11	Санхүүгийн тайланд бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлагыг холбогдох хууль, журмын дагуу зах зээлийн ханшаар үнэлж бүртгэн, оны эцэст малын тоог А дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлж байх.	Мал, амьтдын бүртгэлийг НББ-д зөв тусгуулан сүргийн эргэлтийг залруулан хийлгэж тусгасан болно. 2020 оны малын тооллогыг үнэн зөв хийж А дансаар баталгаажуулахыг төсөвт байгууллагуудын нягтлан бодогчдоод хариуцуулсан.	Төсөвт байгууллагууд хөрөнгөд бүртгэлтэй малын нас дэвшилтийн хөдөлгөөнийг бүртгээгүй, туслах аж ахуйн орлогыг дансанд бүрэн оруулаагүй, малын тоог А дансаар баталгаажуулах байдал хангалтгүй байна. Аудитаар мал амьтны бүртгэлтэй төсөвт байгууллагуудыг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авсан бүртгэлтэй тулган шалгахад Баянговь, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдын ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЭМТ, Баянхонгор аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын дансанд бүртгэлтэй мал статистикийн хэлтэст байгууллагууд нэр дээр бүртгээгүй, мөн Баянбулаг сумын ЗДТГ, Баянцагаан сумын ЭМТ, Бууцагаан сумын “Баян”, “Баянбүрд”, “Наран” багийн нэр дээр нийт 311 толгой мал бүртгэлтэй байгаа ч тус байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлгүй байна. Биелэлт 70%
12	Төсөвт байгууллагуудын биет бус хөрөнгөд бүртгэлтэй боловч ашиглалтгүй программ хангамжуудыг цаашид ашиглах боломжтой эсэхийг мэргэжлийн байгууллагаас тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Программ ашиглалтын судалгаа гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 108 дугаар тогтоолоор 75 байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 84.6 сая төгрөгийн ашиглалтгүй программ хангамжийг акталж данснаас хасах шийдвэр гаргуулж данснаас хассан байна. Биелэлт 100%
13	Баянговь сумын төрийн сангийн арилжааны банкин дахь дансыг хаах хүсэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах.	Арилжааны банкин дахь дансыг хаалгасан.	Арилжааны банкин дахь дансыг хаалгах хүсэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон. Биелэлт 100%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			67.0%

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 158 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 21 төрийн сангийн санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс, байгаль хамгаалах сан, засаг даргын нөөц хөрөнгө нийт 237 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 230 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 138 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 73 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 19 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 18 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит “Баянхонгор Нью майнинг” ХХК-ыг, 88 дугаар тогтоолоор “Хонго шинэ агро” ОНӨААТҮГ-ыг, 87 дугаар тогтоолоор “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ-ыг тус тус татан буулгах шийдвэр гарсны дагуу хаалтын баланс гаргаж нэгтгэсэн байна.

Мөн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлант жилд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд насан туршийн боловсролын төв, хувийн цэцэрлэг, сургууль, орон нутгийн нөөц хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, мал хамгаалах сан зэрэг 8 байгууллага, сангийн орлого, зарлагын гүйлгээг хамрагдаж нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 73 байгууллагыг түүвэрт хамруулж, 138 байгууллагад дүгнэлт хүргүүлснээс 118 байгууллагад “Зөрчилгүй”, 19 байгууллагад “Хязгаарлалттай”, 2 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7652.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2262.9 сая төгрөгийн 98 алдааг санхүүгийн тайланд залруулж, 521.5 сая төгрөгийн зөрчилд 96 төлбөрийн акт тогтоож, 1436.2 сая төгрөгийн зөрчилд 89 албан шаардлага хүргүүлж, 3431.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 353 зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал санхүүгийн тайланд залруулсан алдаа 1061.5 сая төгрөгөөр буурч, залруулагдаагүй алдаа 241.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс акт, албан шаардлагын дүн 1847.7 сая төгрөгөөр буурсан ч зөвлөмж 2088.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 24. Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /сая.төг/

Он	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Залруулагдаагүй алдааны дүн	Санхүүгийн тайланд залруулсан алдааны дүн	Нийт алдааны дүн
2019	957.9	2,847.5	1,343.0	5,148.4	3,324.4	8,472.8
2020	521.5	1,436.2	3,431.9	5,389.6	2,262.9	7,652.5
Өөрчлөлт	(436.4)	(1,411.3)	2,088.9	241.2	(1,061.5)	(820.3)

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагын нийт зөрчлийг тоог өмнөх онтой харьцуулахад алдаа зөрчлийн дүн 820.3 сая төгрөгөөр буурсан ч, залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 241.2 сая төгрөгөөр нэмэгдсэн зөрчилтэй саналт, дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос буурахгүй байгаа нь дараах зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

1. Аймаг, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар анхан шатны баримтын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гүйлгээнд тавих хяналт хангалтгүй, төсвийн хуваарьт өөрчлөлт орж, шинэчлэгдсэн хуваарь батлагдаагүй байхад мөн төсвийн захирагч, нягтлан бодогч нарын гарын үсэг зурагдаагүй байхад зарим гүйлгээг хийдэг;
2. Эд хариуцагч бараа материалын тайланг батлагдсан маягтын дагуу анхан шатны баримтад үндэслэн сар бүр гаргаагүй байхад нягтлан бодогч хяналт тавиагүй, ;
3. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын дагуу зарлагын гүйлгээг бүрэн хянаагүй;
4. Сангийн яамны Э-тайланд нягтлан бодогч нар аудитлагдсан санхүүгийн тайланг оруулахдаа зөрүүтэй оруулж төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байхад–санхүүгийн албаны дарга нар хянаагүй;

5. Цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст үнэн зөв мэдээлдэггүй, даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс авлага, өглөг үүссэн байхад залруулга хийдэггүй;
6. Зарим байгууллага бараа материал дансанд модемын сунгалт, ногоотой шөл, ажлын хөлс зэрэг шууд зардлыг бараа материалын дансанд орлогоор бүртгэж тайлагнасан;
7. Эд хөрөнгийн тооллогын комисст эд хариуцагч, нягтлан бодогчийг оруулсан. Мөн бараа материалыг тоолдоггүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж даргын тушаалаар баталгаажуулдаггүй;
8. Эргэлтийн хөрөнгийг акталж данснаас хасахдаа даргын тушаал гаргаагүй, мөн устгал хийсэн баримтыг үйлдээгүй;
9. Сумдын ЗДТГ-ууд аймгийн Сум дундын ойн ангиас нийлүүлсэн өвс тэжээлийн тооцоог нийлж, санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй;
10. Үндсэн хөрөнгийг ашиглах жилийг программд -1, 0, 2019 гэх мэтээр буруу оруулснаас тайлант жилийн элэгдлийн зардлыг буруу тайлагнасан;
11. Хэмнэгдсэн зардлыг оны эцэст эд хогшил худалдан авах зардалд нэмж зохицуулалт хийж, шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагаас хөрөнгийг хүлээн аваагүй байхад мөнгийг шилжүүлсэн;
12. Байгууллагын дарга нар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй гэсэн шалтгаанаар амралтын нөхөн олговор, цалин давхардуулан авсан;
13. Байгууллагын дарга нар тушаал гаргаж өөртөө хоол, унааны мөнгө, түлшний хөнгөлөлт авсан;
14. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт байгууллагын дарга хяналтыг тухай бүр хийж баталгаажуулдаггүй, нягтлан бодогч нар өөрсдөө хийж баталгаажуулж байгаагаас хяналт суларч байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулдаггүй;

Иймд дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх, Төсвийн шууд захирагчдын төсвийн тухай хуулийн талаарх мэдлэг, сахилга батыг дээшлүүлэх, санхүүгийн ажилтнуудын санхүүгийн сахилга бат, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх талаар аймгийн СТСХ-ийн мэргэжилтнүүд анхаарч, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Хөгжимт драмын театрын үндсэн хөрөнгийн элэгдлийг 7.1 сая төгрөгөөр дутуу, аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 9.9 сая байгууллагаас авах авлагыг хувь хүнээс авах авлагаар, “Оточ мандал” өрхийн эмнэлгийн 9.4 сая төгрөгийн авлагыг урьдчилж төлсөн зардлаар нэгтгэснийг санхүүгийн тайланд залруулсан.
- Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд Хөгжимт драмын театрын элэгдлийн зардлыг 7.1 сая төгрөгөөр дутуу, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болох 26.8 сая төгрөгийг зардлын төрлөөр салгаагүй нэгтгэснийг санхүүгийн тайланд залруулав.
- Хүрээмарал 0.3 сая, Богд 2.2 сая, нийт 2.5 сая төгрөгийн сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлагыг санхүүгийн нэгтгэсэн тайланд хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэснийг хувь хүмүүст олгосон зээлийн авлагаар залруулав.
- Зам гүүрний байгууламж дансанд Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар 245.1 сая төгрөгийн дулааны шугам, сүлжээ, Баацагаан сумын ЗДТГ 0.7 сая төгрөгийн явган хүний зам, хайс, Галуут сумын цэцэрлэг 1.3 сая төгрөгийн бетонон талбай, ОО зэрэг нийт 247.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэснийг санхүүгийн тайланд залруулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Аудитаар мал амьтны бүртгэлтэй төсөвт байгууллагуудыг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авсан бүртгэлтэй тулган шалгахад Баянговь, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдын ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЭМТ, Баянхонгор аймгийн Хот тохижилт

үйлчилгээний газрын дансанд бүртгэлтэй мал статистикийн хэлтэст байгууллагын нэр дээр бүртгээгүй, мөн Баянбулаг сумын ЗДТГ, Баянцагаан сумын ЭМТ, Бууцагаан сумын “Баян”, “Баянбүрд”, “Наран” багийн нэр дээр нийт 311 толгой мал бүртгэлтэй байгаа ч тус байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “ Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал”, “Оршин байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид санхүүгийн тайланд бүртгэлгүй малыг холбогдох стандартын дагуу үнэлж бүртгэх, бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлага малын тоог “А” дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

2. Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь заалтын дагуу Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулах, тус ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь заалтын дагуу Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавьж шийдвэрлүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3014.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1232.2 сая төгрөгийн 29 алдааг залруулж, 14.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1767.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 56 зөвлөмж өглөө.

ТТЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн нийтлэг зөрчил нь Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу оруулсантай холбоотой тул цаашид сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

Харьяа төсвийн байгууллагаас 19 байгууллагад итгэл үзүүлж, 69 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 112 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 93 байгууллагад “Зөрчилгүй”, 18 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3872.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 949.3 сая төгрөгийн 61 алдааг залруулж, 220.3 сая төгрөгийн зөрчилд 85 төлбөрийн акт тогтоож, 1345.3 сая төгрөгийн зөрчилд 85 албан шаардлага хүргүүлж, 1357.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 264 зөвлөмж өглөө.

Хүснэгт 25. “Хязгаарлалттай”, “Сөрөг” санал дүгнэлт авсан төсвийн шууд захирагч

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ	Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, өмнөх оны зөвлөмж, төлбөрийн актыг бүрэн биелүүлээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил давтагдсан, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын аж ахуйн материалын дүн санхүүгийн тайлангаарх үлдэгдлээс 1330.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, ерөнхий нягтлан бодогч тооцоо бодсон акт бодоогүй, тооллогын бүртгэлийг баталгаажуулах тушаалыг байгууллагын удирдлага гараагүй, оны эцэст санхүүгийн тайланд бүртгэлтэй 85279.6 мянган төгрөгийн авлага, 27955.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 2019 оны зардлын 20195.5 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Тохиолдсон байх”, Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.
БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭМ АХЛАХ СУРГУУЛЬ	Тус сургуулийн гадна фасадын засварын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо ажил гүйцэтгэх гэрээний 2.1, 2.2 дахь заалтыг зөрчиж ажлын гүйцэтгэлийн баталгаажуулалгүй 44880,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн 2020 оны 12 дугаар сард сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлээд тухайн хөрөнгийг тайлант онд хүлээж аваагүй байж тооллогын бүртгэлд биетээр байгаагаар баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй.
БАЯНХОНГОР СУМ 13-Р ЦЭЦЭРЛЭГ	Захирал нягтлан бодогч нар нь амралтын цалин болон үр дүнгийн урамшуулал авахдаа 2709,1 мянган төгрөгийг давхардуулан авсан. “Шунхлай трейдинг” ХХК-руу 2020.12.14-нд 1000,0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн боловч эд хариуцагчийн тайланд замын хуудас байхгүй. Хандив тусламжаар авсан 245,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагад тусгагдаагүй, тооллого явуулахад агуулахад байхгүй, хүүхдүүдэд тараасан гэх тайлбар өгсөн боловч баримтаар нотлогдохгүй байна. “Дэвших болор” ХХК-нд 12257,1 мянган төгрөг шилжүүлсэн боловч бараа материалыг хүлээн авах акт үйлдээгүй хүлээн авсан эсэх нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 13.4 дэх заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ээлжийн амралт олгох заавар”-тай заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БАЯНХОНГОР СУМЫН 15-Р ЦЭЦЭРЛЭГ	Байгууллагын даргын 2020 оны 49 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комиссыг томилсон ч эд хөрөнгийг бүрэн тоолсон эсэхийг нотлох боломжгүй; Байгууллагын нярав сар бүр бараа материалын тайланг гаргаагүй байхад нягтлан бодогч бараа материалын дэлгэрэнгүй болон хураангуй журнал хөтөлж бүртгэл тайланд тусгасан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 13 дугаар зүйлийн 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
	байдал”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БАЯНХОНГОР СУМЫН 3-Р ЦЭЦЭРЛЭГ	Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 20 ний өдрийн А/45 дугаар тушаалаар тооллогын комиссыг томилсон ч хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодсон баримт байхгүй, тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл нярвын тайлангийн үлдэгдлээс 6117,5 төгрөгөөр зөрүүтэй. Бэлтгэн нийлүүлэгч рүү 5143,0 мянган төгрөг шилжүүлээд бэлнээр гаргуулан авч 3468.0 мянган төгрөгөөр дроз худалдан авсан, 1675.0 мянган төгрөгөөр хүүхдийн шкаф захиалаад хүлээн аваагүй байж санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6, 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БАЯНБУЛАГ СУМЫН ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс 6160.0 мянган төгрөгийн автомашин худалдан авч зориулалт бусаар зарцуулсан, эд хөрөнгийн тооллогын комисс жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 63924.4 мянган төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж даргын тушаалаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БАЯНЛИГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	Тооллогын бүртгэл ирүүлээгүй, бараа материалын тодруулгад 1153,4 мянган төгрөгийн эм боох материалын орлого зарлага байгаа боловч эд хариуцагчийн тайлан байхгүй. Бараа үйлчилгээний бусад зардлаас 19550,0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, хөрөнгөөс "Санко маркетинг Монголиа" ХХК-ийн нийлүүлсэн 9950,0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нь ирээгүй байхад хөрөнгөд орлогоор бүртгэсэн, "ЭБЦТС" ТӨХК-д 226,8 мянган төгрөгийн өглөгтэй байхад тайланд тусгаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 13.4, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР	Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 03/1690 тоот албан бичгээр өгсөн мэдэгдлийг зөрчин аймгийн Засаг даргын 2020.05.19-ны өдөр А/348 тоот захирамжаар Хөгжлийн бодлогын хэлтэст худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг даалгуулсан бөгөөд тус дуудлага худалдаа нь 2020.05.25, 2020.06.26-ны өдөр тус тус зарлагдаж амжилтгүй болсон. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 169-р тогтоолыг зөрчин аймгийн Засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийг нэмж нийт 147700.0 мянган төгрөгөөр захиалагчийн хяналтын зардлаас суудлын автомашин худалдан авах зөвшөөрөл гаргуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4 дүгээр зүйлийн 30.4.1 дэх заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.
БАЯНХОНГОР АЙМГИЙН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНТУГ	Тайлант онд тус байгууллагын дарга нар иргэн , аж ахуйн нэгж байгууллагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, цэцгийн үрсэлгээ, хөрс, бор шороо, давс, хайсны бэлдэц зэргийг худалдан авахаар 89499.1 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулж холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн. Баянхонгор сумын 4.5-р багийн нутаг дэвсгэрт замын засварын ажил хийгдээгүй байхад, гэрээнд зааснаас өөр ажлын гүйцэтгэж 8780.1 мянган төгрөгийг олгосон, “ЦЭСДА” ХХК-аар барилга байгууламжийн зураг төсөв хийлгэхээр 9980.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн зураг төсвийг хийлгээгүй, ажилчдын орон сууцны зураг төсвийг хийлгэж өмнөх оны авлагыг хаасан, байгууллагын даргын 2020.12.08 өдрийн 71 тоот тушаалаар тооллогын комисс тооллогын ажлыг зохион байгуулсан илтгэх хуудас бичсэн боловч тооллогыг хийсэн бүртгэл байхгүй, Баянхонгор сумын ИТХ-ын тогтоолоор эзэмшүүлсэн хөрөнгөөс 254747.6 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн орлого аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, 20.1.4 дэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй
БОГД СУМЫН ЗДТГ	Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 41500.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
	байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй, Шилэн дансны тухай хуулийн дагуу 2020 оны төсвийн мэдээллийг ил тод, иж бүрэн мэдээлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	"Байгууллагын дарга тушаал гаргаагүй байхад 6707.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан, кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын бэлтгэж гаргаагүй, нягтлан бодогч санхүүгийн программд бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.
БӨМБӨГӨР СУМЫН ЗДТГ	Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон боловч үр дүнг даргын тушаалаар баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн. Нэмэлт санхүүжилтийн дансны 18225.7 мянган төгрөгийн орлого, 5061.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны болон бараа материалын дансанд тусгаж нярвын тайлан гаргаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, дэх заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
БУУЦАГААН СУМЫН ЗДТГ	Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй, кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын бэлтгэж гаргаагүй, анхан шатны баримтыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	Тус байгууллагын спорт заалны шалны засварын ажлын худалдан авах ажиллагааг 2020 оны 09 дүгээр сард зарлан 12 дугаар сарын 10-нд "Хаст шонхор" ХХК-тай ажлыг 2020.12.20-ы дотор гүйцэтгүүлэхээр 23002.9 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлж ажлыг гүйцэтгээгүй байхад 2020.12.22-ны өдөр 21047.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож авлагаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй.
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ	Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийгээгүй, бараа материалын нярвын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс нийт дүнгээрээ 5564.1 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнагдсан. Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А/38, А/48, А/168, А/174, А/133 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй олгосон 6947,2 мянга, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 974.8 мянга, нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууныг орлогод аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлагналын “Үнэн зөв байдал”, “Оршин байх”, “Иж бүрэн байх”, “Үнэлгээ”, “Хэмжилт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
ЖИНСТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	Сургуулийн захирлын 2020.12.08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон гэх боловч тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо бодсон акт үйлдээгүй. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тайлант онд нярвын хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт болон ачаа тээврийн зардал төлсөн баримт байхгүй зэрэг зөрчлийг дахин давтан гаргасан. Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулалгүйгээр халаалтын зардлаас 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 6800.0 мянган төгрөгийн шатах тослох материал, үдийн цайны зардлаас 5200.0 мянган төгрөгийн шатах тослох материал тус тус бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Төсвийн байгууллагын үйл ажиллагааны мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтууд Санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	Байгууллагын даргын 2020.12.15-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисс байгуулахдаа бүрэлдэхүүнд нь нярвыг оруулсан, санхүүгийн тайланд үлдэгдлээр байгаа бараа материалаас 15670.0 мянга, үндсэн хөрөнгөөс 60967.8 мянга, нийт 76637.8 мянган төгрөгийн бүртгэлтэй хөрөнгийг тооллогын комисс тоолоогүй, нягтлан бодогч тооцоо акт үйлдээгүй, байгууллагын нярав, нягтлан бодогч нар хөрөнгийг авсан тухай бүрд орлогод авдаггүй, авсан хугацаанаас хойш төлбөрийг шилжүүлэхдээ нярвын тайланг гаргаж, санхүүгийн программд бүртгэн нягтлан бодох бүртгэлийг акруэл сууриар

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
	хөтлөөгүй, нярав бараа материалын тайланг гаргахдаа эхний үлдэгдлийг материал тус бүрээр гаргалгүй бөөн дүнгээр гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗДТГ	Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газар нь Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57600.0 мянган төгрөгийн үнэ бүхий дизель мотор биетээр байхгүй тооллогоор дутсан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамжаар тус дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон ч захирамжийн хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй.
"СӨРӨГ САНАЛ ДҮГНЭЛТ"	
БАЯНХОНГОР СУМЫН 11-Р ЦЭЦЭРЛЭГ	Тайланд онд бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн 15294.4 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан бөгөөд бараа худалдан авсан, урсгал засвар хийлгэсэн эсэх нь тодорхойгүй, нярав орлого аваагүй, анх шатны бүртгэл тайланд тусгагдаагүйгээс нотлох боломжгүй; Бараа материалын тайланд 7020.0 мянган төгрөгийг дроз, 2345.0 мянган төгрөгийн тоглоомын багц орлогод авч бүртгэсэн боловч аудитын тулган баталгаажуулалтаар тухайн хөрөнгүүдийг хүлээн аваагүй мөн дээрх шилжүүлсэн 2345,0 мянган төгрөгийг нийлүүлэгч аж ахуйн нэгжээс мөнгийг бэлнээр авсан болох нь тогтоогдсон; Жилийн эцсийн тооллого хийж тооцоо бодоогүй, хүнсний материалын үлдэгдэл 1069.6 мянган төгрөгийн хүнсийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад буцааж шилжүүлсэн гэх боловч акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Толилуулга ба тодруулга”, “Үнэлгээ”, “Иж бүрэн байх”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй.

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, тайлант онд татан буугдсан 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн дуусгалтын тайлан нэгтгэгдэж байна.

Аймгийн Засаг даргын харьяа 4 өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгснөөс “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 766.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 81.4 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 286.8 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 90.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 307.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 33 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 26. “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
"ЦЭВЭР ХОТ" ОНӨААТҮГ	Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хог тээвэрлэх гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, хог тээврийн ААНБ-ын орлогыг бэлэн мөнгөний баримт бичин хураан авч байгаа боловч бүртгэлээр тавих хяналт байхгүй, сар бүр кассын тайлан гаргаж, үйлчлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй, кассын орлогыг тулган шалгахад 2020 оны 1-8 сарын кассын орлого 7501,0 мянган төгрөгийг борлуулалтын ажилтан өөрийн харилцах дансаар дамжуулан 4250.0 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлж, 3250.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсныг санхүүгийн тайланд орлого, зардлаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.
ШИНЭЖИНСТ СУМЫН ТОХИЖИЛТ	"Эрдэнэ монгол" ХХК-с тус байгууллагад 6000.0 мянган төгрөгийн мөнгөн хандивыг дансаараа дамжуулан иргэдэд олгосон, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 6050.0 мянган төгрөг аж ахуйн нэгжүүдээс орсныг зарцуулсан, тус байгууллагын 4 ажилтанд 2020 онд 200.0-650.0 мянган төгрөгийн нийт 18733.0 мянган төгрөгийн цалин

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА	олгосон боловч цалингаас НДШ, ХХОАТ-ыг хуулийн дагуу суутган тооцоо хийгээгүй, ажил олгогчоос төлөх НДШ төлөөгүй, нийгмийн даатгалын мэдээг гаргаж өгөөгүй, Нягтлан бодох бүртгэлийг НББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримт бүрдүүлэх, журналд бичих, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, гүйлгээ баланс гаргах, санхүүгийн тайлан гаргах дарааллын дагуу гүйцэтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 25.5, 25.5.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 гэсэн заалтууд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд тус сумдад байгуулсан “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг хөрөнгийн бүртгэлд хөрөнгө тус бүрийн нэр төрөл, үнийн задаргаа гаргаагүй нийт дүнгээр сум бүрт 920.0 сая төгрөгөөр тус тус бүртгэлтэй байгаа ба тус хөрөнгүүдээс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байгаа тул хөрөнгийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж данснаас хасах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2. ТШЗ-ийн болон ОНӨААН-ийн 8 байгууллагын 666.6. сая төгрөгийн олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн авлагууд нь тооцоо нийлсэн актгүй, олон жил болсноос эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон, аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах болон хөнгөлөлттэй зээлийг үр ашиггүй зүйлд зарцуулж, төсвийн хөрөнгийн үргүйдэх, найдваргүй авлага үүсэх сөрөг үр дагавартай тул ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн ба барагдуулсан талаар дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

3. Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахалтай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандив, түүний зарцуулалтыг тус аудитаар авч үзээгүй тул 2021 оны эхний хагас жилд багтаан шалгах шаардлагатай байна.

4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 87 дугаар тогтоолоор “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ-ын 183.1 сая төгрөгийн өрийн үлдэгдлийг сумдын эргэлтийн эмийн сангуудад хуваарилж, тус газрын хаалтын тайлан балансыг 2020.09.30-ны байдлаар дуусгавар болгож гаргахаар шийдвэрлэсэн байгаа ба дээрх 183.1 сая төгрөгийн өглөгийг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгээгүй байна. Иймд тус аж ахуйн нэгжийн өрийн үлдэгдэл 183.1 сая төгрөгийн барагдуулсан эсэх, мөн сумдын эргэлтийн эмийн сангуудын өмчийн хэлбэрийг аймгийн ИТХ-аас тогтоосон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд тус сумдад байгуулсан “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг хөрөнгийн бүртгэлд хөрөнгө тус бүрийн нэр төрөл, үнийн задаргаа гаргаагүй нийт дүнгээр нь 920.0 сая төгрөгөөр тус тус бүртгэлтэй байгаа ба тус хөрөнгүүдээс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрч үрэгдсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байна.

3.1.2 Эрсдэл: Хөрөнгийг нэр төрлөөр нь бүртгээгүйгээс төсвийн хөрөнгө үрэгдэх, эзэнгүйдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг нэр төрлөөр нь зөв ангилж бүртгэн, ашиглалтгүй хөрөнгүүдийг данснаас хасах шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулж данснаас хасах ажлыг зохион байгуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 16 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл дахин үнэлгээний дэлгэрэнгүй бүртгэлээс 3409.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

3.2.2 Эрсдэл: Дахин үнэлгээний нэмэгдлийг зөрүүтэй тусгаснаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төсөвт байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдлийг хөрөнгө тус бүрээр тулган баталгаажуулж, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд зөрчлийг залруулж бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.3.1 Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Сум дундын ойн ангид бүртгэлтэй Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд төлөх 200.0 сая төгрөгийн өглөг нь гэрээний хугацаа нь 2021 оны 07 дугаар сард дуусах хугацаатай байхад барагдуулаагүй байна.

3.3.2 Эрсдэл: Олон жилийн насжилттай өглөгийг тооцоо нийлж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж: Тус өглөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан төлбөрийг төлөх эсэх талаар шийдвэр гаргуулан өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.4.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст орон нутгийн орлогод 496.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байхад тооцоо нийлж, зайлшгүй өгөх хөрөнгийг авлага, өглөгөөр санхүүгийн тайланд тусгаагүй байна.

3.4.2 Эрсдэл: Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг авлага, өглөгөөр тусгаж баталгаажуулаагүйгээс төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах.

3.4.3 Өгсөн зөвлөмж: Цаашид оны эцэст төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлсэн үлдэгдлийг авлага, өглөгөөр тусгах эсэх талаар шийдвэрийг дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор гаргуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, авлага, өглөгийг тухай бүр холбогдох байгууллагын санхүүгийн тайланд тусгаж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6 Удирдлагын болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 59 мэдээллийг хугацаа хоцроож, хагас жилийн санхүүгийн тайлан, бүтэн жилээр байршуулах аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй, хуулийн 3.1.5-т хамаарах нийт 14 байгууллагын шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих 53 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.



3.6.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.6.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 09 дүгээр сарын 15-ний дотор, холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Бэлтгэсэн:		
АХЛАХ АУДИТОР		Б.ДОЛЖМАА 2021.04.19
АУДИТОР		Ж.ӨСӨХБАЯР 2021.04.19
АУДИТОР		Б.НАРАНГЭРЭЛ 2021.04.19
Анхан шатанд хянасан:		
АУДИТЫН МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ 2021.04.19
Хоёр дахь шатанд хянасан:		
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Б.МӨНХБАТ 2021.04.19



5.Хавсралт 1.:Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/1/СТА-ТЕЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Засаг дарга		сая төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах албан тушаалтны	
A	1	2	3	4	5
1	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд Хөгжимт драмын театрын үндсэн хөрөнгийн элэгдлийг 7.1 сая төгрөгөөр дутуу, аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын 9.9 сая байгууллагаас авах авлагыг хувь хүнээс авах авлагаар, “Оточ мандал” өрхийн эмнэлгийн 9.4 сая төгрөгийн авлагыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн.	9.4	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
2	Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд Хөгжимт драмын театрын элэгдлийн зардлыг 7.1 сая төгрөгөөр дутуу, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болох 26.8 сая төгрөгийг зардлын төрлөөр салгаагүй.	7.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
3	Зам гүүрний байгууламж дансанд Баянхонгор аймгийн Биений тамир спортын газар 245.1 сая төгрөгийн дулааны шугам, сүлжээ, Баацагаан сумын ЗДТГ 0.7 сая төгрөгийн явган хүний зам, хайс, Галуут сумын цэцэрлэг 1.3 сая төгрөгийн бетонон талбай, ОО зэрэг нийт 247.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн.	247.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
4	Аудитаар мал амьтны бүртгэлтэй төсөвт байгууллагуудыг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авсан бүртгэлтэй тулган шалгахад Баянговь, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдын ЗДТГ, Эрдэнэцогт сумын ЭМТ, Баянхонгор аймгийн Хот тохижилт үйлчилгээний газрын дансанд бүртгэлтэй мал статистикийн хэлтэст байгууллагын нэр дээр бүртгээгүй, мөн Баянбулаг сумын ЗДТГ, Баянцагаан сумын ЭМТ, Бууцагаан сумын “Баян”, “Баянбүрд”, “Наран” багийн нэр дээр нийт 311 толгой мал бүртгэлтэй байгаа ч тус байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх.	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
5	Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	333.5	Албан шаардлага хүргүүлэх.	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
6	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих” гэсэн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх.	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
7	Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын ЗДТГ-ын хөрөнгөнд тус сумдад байгуулсан “Сэргээгдэх эрчим хүч”-ний байгууламжийг хөрөнгийн бүртгэлд хөрөнгө тус бүрийн нэр төрөл, үнийн задаргаа гаргаагүй нийт дүнгээр нь 920.0 сая төгрөгөөр тус тус бүртгэлтэй байгаа ба тус хөрөнгүүдээс зарим хэсэг нь ашиглалтгүй болсон, эвдэрч үрэгдсэн байхад анх хөрөнгийг бүртгэхдээ нэр төрлөөр нь үнэлж бүртгээгүйгээс эвдэрсэн хөрөнгүүд данс бүртгэлээс хасагдаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
8	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 16 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл дахин үнэлгээний дэлгэрэнгүй	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга,	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	бүртгэлээс 3409.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.			ерөнхий нягтлан бодогч	
9	Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Сум дундын ойн ангид бүртгэлтэй Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд төлөх 200.0 сая төгрөгийн өглөг нь гэрээний хугацаа нь 2021 оны 07 дугаар сард дуусах хугацаатай байхад барагдуулаагүй байна.	200.0	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
10	Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст орон нутгийн орлогод 496.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байхад тооцоо нийлж, зайлшгүй өгөх хөрөнгийг авлага, өглөгөөр санхүүгийн тайланд тусгаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
11	Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 59 мэдээллийг хугацаа хоцроож, хагас жилийн санхүүгийн тайлан, бүтэн жилээр байршуулах аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй, хуулийн 3.1.5-т хамаарах нийт 14 байгууллагын шилэн дансны цахим сайтад мэдээлбэл зохих 53 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхсайхан, С.Байгальмаа, Ц.Самбууням
Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүн		797.1			

оОо